



МОНГОЛ УЛСЫН ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗРЫН ХАРЬЯА ХОВД АЙМГИЙН АУДИТЫН ГАЗАР

Ховд аймгийн 2016 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан



**БОЛОВСРОЛЫН САЛБАРЫН ТӨСВИЙН ТӨЛӨВЛӨЛТИЙГ САЙЖРУУЛАХ
ШААРДЛАГАТАЙ БАЙНА.**

Ховд хот
2017 оны 4

АГУУЛГА

<u>Аудитын тайланг бэлтгэсэн:</u>	
ҮАГ-ын харьяа	Товчилсон үгийн тайлбар..... 3
Ховд аймгийн	Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй, шалгуур үзүүлэлт..... 4
Аудитын газар	Оршил 5
Дарга, тэргүүлэх аудитор	
Л.Галбадрах	Бүлэг 1. Төсвийн төлөвлөлт6-9
Аудитын менежер	<i>Төсвийн тухай хуулийн дагуу аймгийн ТЕЗ-ын төсвийн орлого, зарлагыг төсвийн бодлого, зорилтуудын хүрээнд төлөвлөсөн ч сангийн яамнаас хянасан төсвөөс 2001,2 сая төгрөгөөр нэмэгдүүлж баталсан төдийгүй зарим сан, боловсролын байгууллагуудын төсвийг бодиттой төлөвлөх шаардлагатай байна.</i>
А.Цэцэгсүрэн	Бүлэг 2 Төсвийн орлогын бүрдүүлэлт.....9-12
Ахлах Аудитор	<i>Орон нутгийн татварын орлого өмнөх оноос 165,0 сая төгрөгөөр нэмэгдсэн ч зарим нэр төрлийн татварын орлого тасарч баталсан дүнгээс 397,8 сая төгрөгөөр татварын орлого тасарсан байна.</i>
Д.Хишгээ	Бүлэг 3 Төсвийн зарлагын гүйцэтгэл12-19
Аудитор	<i>Зардлыг зүйл анги бүрээр баталсан дүнтэй харьцуулахад цалин хөлс, тогтмол зардлуудыг 368,9 сая төгрөгөөр хэмнэж бусад бараа үйлчилгээний зардалд гүйлгэн зарцуулжээ.</i>
Д.Нарантуул	Бүлэг 4.Төсвийн үр дүнгийн үзүүлэлт.19
2017 оны 4 дүгээр	<i>Өмнөх оны гүйцэтгэлээс тайлант оны зардал 2538.8 сая төгрөгөөр өсөж, баталсан дүнгээс нийт зарлагыг 1468,4 сая төгрөгөөр дутуу санхүүжүүлж (-440,8) сая төгрөгийн үр дүнтэй ажиллажээ.</i>
Аудитын тайлан, дүгнэлттэй холбоотой асуудлаар нэмж тодруулах, асууж лавлах зүйл байвал 70432736 дугаарын утсаар харилцана уу.	Ерөнхий дүгнэлт.....19-20
ХАЯГ:	Зөвлөмж.....20
Ховд аймгийн	Тэргүүлэх аудиторовын тушаал
Засаг даргын	Холбогдох байгууллагаас ирүүлсэн санал
тамгын газар	Хавсралт судалгаа.....

Товчилсон үгийн жагсаалт

УИХ	Улсын Их Хурал
ҮАГ	Үндэсний Аудитын Газар
ААГ	Аймгийн аудитын газар
ИТХ	Иргэдийн Төлөөлөгчдийн хурал
ЗДТГ	Засаг даргын тамгын газар
ТЕЗ	Төсвийн ерөнхийлөн захирагч
ТЗШ	Тусгай зориулалтын шилжүүлэг
ТТЗ	Төсвийн төвлөрүүлэн захирагч
ОНӨААТҮГ	Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар
СТА	Санхүүгийн тайлангийн аудит
ТБОНӨХБАҮХА	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль
ХК	Хязгаарлагдмал компани
ТШЗ	Төсвийн шууд захирагч
ААН	Аж ахуйн нэгж
ОН	Орон нутаг
СХС	Сум хөгжүүлэх сан
АТӨЯХ	Авто тээвэр өөрөө явагч хэрэгсэл
ОНХС	Орон нутгийн хөгжлийн сан
НӨАТ	Нэмүү өртөгийн албан татвар
БОАЖГ	Байгаль орчин аялал жуучлалын газар
СТСХ	Санхүү, төрийн сангийн хэлтэс

Аудитыг Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.10.2-т заасны дагуу Монгол Улсын Ерөнхий аудиторт Үндэсний Аудитын газраас 2017 онд нийлүүлэх бүтээгдэхүүн, ажил, үйлчилгээний төлөвлөгөөг ᠵᠢᠠᠭᠦᠨᠡᠳᠡᠶᠢ ᠣᠷ᠔ᠡᠶᠢ ᠠ᠋ᠣ᠎ᠠᠭᠤᠯᠢ ᠰᠣᠪᠡᠬᠡᠲᠤ ᠣᠢᠠᠨᠳᠣᠹᠡᠭᠡᠨᠢ ᠠᠡᠯᠡᠭᠡᠭᠡ ᠠᠣ᠎ᠠᠭᠤᠯᠢ ᠸᠠᠴᠣᠨᠢ ᠠᠵᠣᠶᠢ ᠶᠣᠳᠡᠶᠢ ᠳᠠᠵᠣᠶᠢ ᠠᠳᠡᠶᠢ.

Ховд аймгийн 2016 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэл үнэн зөв илэрхийлэгдсэн эсэхийг шалгаж, дүгнэлт гарган ҮАГ-т хүргүүлэх, Аймгийн ИТХ, Засаг даргад танилцуулахад аудитын зорилт чиглэгдэнэ.

Уг зорилтыг хэрэгжүүлэхийн тулд дараахь чиглэлээр аудитыг гүйцэтгэнэ Үүнд :

- ✚ Нэгдсэн төсвийн орлого, зарлагын төлөвлөлтийн үндэслэл
- ✚ Нэгдсэн төсвийн орлогын гүйцэтгэл
- ✚ Нэгдсэн төсвийн зарлагын гүйцэтгэл
- ✚ Нэгдсэн төсвийн үр дүнгийн үзүүлэлт

Àòáèòùí çí ðèèòù ã òàí ãáí áèáèççýðèéí òòèä Ховд аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн төсвийн гүйцэтгэлийн тайлан,çéé àæèèäãáí û áàðè ò ì àòáèèäè, òàééàí òýí òýè, õí éáí ãáí ò áóñàà ì àòáèèäèòóáàà òòèäòóðèáí ãéöýòýá.

Аудитыг гүйцэтгэхэд Төрийн хяналт шалгалтын стандарт, гүйцэтгэлийн болон санхүүгийн аудитын арга зүйг ашиглан холбогдох албан тушаалтнуудтай ярилцлага хийх, асуулга, лавлагаа авах, тайлан баримт материалд тулган баталгаажуулалт, дүн шинжилгээ хийх зэрэг арга зүйг ашиглахын зэрэгцээ аудитын судалгаа хөтөлбөр, горимын дагуу нотлох зүйл цуглуулж, дүгнэлт, зөвлөмж боловсруулна.

Аудитад дараахь хууль, тогтоомжийг шалгуур үзүүлэлт болгов.Үүнд: Монгол Улсын Үндсэн хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Төсвийн тухай хууль, Монгол Улсын 2016 оны төсвийн тухай хууль, Нийгмийн даатгалын багц хуулиуд, Төрийн аудитын тухай хууль, Татварын багц хуулиуд, аймгийн ИТХ-ын тогтоолууд, Засаг даргын захирамжууд болон холбогдох бусад хууль тогтоомж, эрхийн актууд

Аудитыг ҮАГ-ын харьяа Ховд аймгийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор Ч.Галбадрах удирдан, аудитын менежер А.Цэцэгсүрэн хянаж, ахлах аудитор, Д.Хишгээ, аудитор Д.Нарантуул нар 2017 оны 4-р сарын 05-наас 2017 оны 4-р сарын 19-ныг хүртэл хугацаанд хийж гүйцэтгэв.

Ховд аймгийн 2016 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлангийн I бүлэгт төсвийн төлөвлөлтийн талаар, II бүлэгт төсвийн орлогын бүрдүүлэлт, III бүлэгт төсвийн зарлагын талаар, IV бүлэгт төсвийн үр дүнгийн талаар тусган аудитын дүгнэлт, зөвлөмж, холбогдох газрын санал гэсэн агуулгаар бичигдлээ.

ОРШИЛ

Аймаг, сумдын төрийн сангийн системд нийт 222 байгууллагын 703 данс байршиж байгаагаас аймгийн төвийн төрийн санд улсын болон орон нутгийн 135 данс, сумдын төрийн санд 568 дансаар 171,5 тэрбум төгрөгийн мөнгөн урсгалын гүйлгээг холбогдох хууль тогтоомжийн дагуу тухай бүр хийж харилцагч байгууллага, иргэдэд санхүүгийн үйлчилгээг үзүүлж байна.

Аймгийн ИТХ-аас урсгал болон хөрөнгийн зардлыг бууруулах, орлогын боломжит эх үүсвэрийг нэмэгдүүлэх, тэвчиж болох зардлыг хэмнэх, үргүй зардлыг бууруулах бодлого баримтлан ТЕЗ-ын нэгдсэн төсвийг анх 59317,4 сая төгрөгөөр баталсан бол оны эцэст тодотгол хийж 60684,4 сая төгрөгөөр баталсан байна.

ОН-ийн ТЕЗ-ийн санхүүгийн нэгтгэсэн тайланд нэгтгэдэг орон нутгаас санхүүждэг аудитад хамрагдвал зохих 224 байгууллагаас 223 байгууллага аудитад хамрагдан 94 байгууллагыг түүвэрлэн хянаж, 3 байгууллагад итгэл үзүүлж, 127 байгууллагад дүгнэлт гаргасан байна. Эе эвийн хүч ОНӨААТҮГ-ын удирдлага солигдсон, үйл ажиллагаа явуулаагүйгээс аудитад хамрагдаагүй байна.

Орон нутгийн 17 төсвийн төвлөрүүлэн захирагч, 28 орон нутгийн өмчийн болон өмчийн оролцоотой ААН, 85 төсвийн шууд захирагчийн 2016 оны санхүүгийн тайланд аудит хийж 13 тэрбум 420,6 сая төгрөгийн алдаа, зөрчил илрүүлснээс 7 тэрбум 645,4 сая төгрөгийн материаллаг алдааг залруулж, 4 тэрбум 600,6 сая төгрөгийн зөрчил, дутагдлыг арилгуулах зөвлөмж өгч, 139,4 сая төгрөгийн 44 акт, 1 тэрбум 35,8 сая төгрөгийн 33 албан шаардлага бичсэн байна.

Аудитаар ОН-ийн төсвийн ерөнхийлөн захирагчдын санхүүгийн нэгтгэсэн 86 тайланд зөрчилгүй, 40 тайланд хязгаарлалттай санал дүгнэлт өгсөн байна. Хязгаарлалттай дүгнэлт авсан 40 байгууллагын 13 байгууллага нь орон нутгийн өмчит болон өмчийн оролцоотой ААН-ын тайлангууд байгаагаас үзэхэд төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой ААН-үүдийн нягтлан бодох бүртгэлийн болон тайлагналын стандарт шаардлагыг бүрэн хангаж чадаагүй байна гэсэн дүгнэлт гарч байна.

Төсвийн тухай хуульд заасны дагуу төсвийн ерөнхийлөн захирагчдын бүтцэд дотоод аудитыг хэрэгжүүлэх чиг үүрэг бүхий нэгж байгуулагдан ажиллаж байна.

Тус алба нь 2016 онд үйл ажиллагааны төлөвлөгөө, хяналт шалгалтын графикаар 8 сумын 56 төсөвт байгууллага болон аймгийн төвийн 45 төсөвт байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит үйлдвэрийн газар бүгд 101 байгууллагад хяналт шалгалт хийхээр төлөвлөж, гүйцэтгэлээр аймгийн төвийн 39 байгууллагад төлөвлөгөөт шалгалт хийж 206,0 сая төгрөгний төлбөр зөрчил илрүүлсэн байгаа нь нийт хяналт хэрэгжүүлбэл зохих байгууллагынхаа 38,6 хувийг хамруулсан тоон мэдээтэй байна.

Төрийн сангийн дотоод хяналтыг хэрэгжүүлдэг 1 мэргэжилтэн ажилладаг бөгөөд 2016 онд ганцхан Чандмань сумын төрийн сангийн үйл ажиллагаанд мөрдөх хууль эрх зүйн актын хэрэгжилтийг шалгаж эдийн засгийн ангилал зөрчсөн гүйлгээг байгууллага бүрээр гарган дүгнэлт, зөвлөмж хүргүүлэн ажилласан тайлангаас өөр ажил хийгдээгүй байна.

БҮЛЭГ 1.ОРОН НУТГИЙН ОРЛОГО, ЗАРЛАГЫН ТӨЛӨВЛӨЛТ

Төсвийн тухай хуулийн дагуу аймгийн ТЕЗ-ын төсвийн орлого, зарлагыг төсвийн бодлого, зорилтуудын хүрээнд төлөвлөсөн ч сангийн яамнаас хянасан төсвөөс 2001,2 сая төгрөгөөр нэмэгдүүлж баталсан төдийгүй зарим сан, боловсролын байгууллагуудын төсвийг бодиттой төлөвлөх шаардлагатай байна.

- 1.1. Аймгийн ИТХ-аас 2016 оны төсвийг төлөвлөхдөө татварын хуулиудад орсон өөрчлөлт, төсвийн орлогын боломжит эх үүсвэрүүдийг бүрэн дайчлан, татварын тэгш, шударга байх зарчмыг баримтлан татвар хураалтыг сайжруулан, орон нутгийн татварын хувь хэмжээг нэмэгдүүлэхгүйгээр, татварын бааз, суурийг өргөжүүлэх замаар төсвийн орлогыг бүрдүүлэх бодлого баримтлан боловсруулжээ.
- 1.2. Ховд аймгийн ИТХ-ын тогтоолоор нийт орлогыг 2 удаа тодотгол хийж ТЕЗ-ын төсвийг баталжээ. 2015 оны 12 дугаар сарын 03-ны өдрийн Иргэдийн төлөөлөгчдийн Хурлын 9/07 тоот тогтоолоор анх 59317,4 сая төгрөгөөр, 2016 оны 5 дугаар сарын 16-ны өдрийн 03 тоот тогтоолоор 59438,3 сая , 2016 оны 10 сарын 21-ны өдрийн 03 тоот тогтоолоор 60684,4 сая төгрөгөөр байхаар орон нутгийн нийт орлогыг тус тус тодотгон баталсан байна. Тодотгосон орлогыг хүснэгтээр харуулбал: /сая .төг/

Үзүүлэлт	Сангийн яамны хянасан дүн	2016 он		
		Анх батлагдсан 2015-12-03 № 9/07	Тодотгол-1 2016-05-16-№ 03	Тодотгол-2 2016-10-21-№ 04
ИТХ-ын шийдвэрийн огноо, дугаар				
ОРОН НУТГИЙН ТӨСВИЙН СУУРЬ				
ОРЛОГО	58,683.2	59,317.4	59,438.3	60,684.4
НИЙТ ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН	58,683.2	59,317.4	59,438.3	60,684.4
УРСГАЛ ОРЛОГО	9,199.3	9,856.0	9,856.0	11,240.2
Татварын орлого	8,455.9	8,825.2	8,825.2	8,240.7
Татварын бус орлого	743.4	1,030.8	1,030.8	2,999.5
ХӨРӨНГИЙН ОРЛОГО	-	100.0	100.0	110.0
ТУСЛАМЖИЙН ОРЛОГО	49,483.9	49,361.4	49,482.3	49,334.2
ОРОН НУТГИЙН ТӨСВИЙН СУУРЬ				
ЗАРЛАГА	58,683.2	59,317.4	59,438.3	60,684.4
НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	58,683.2	59,317.4	59,438.3	60,684.4
УРСГАЛ ЗАРДАЛ	54,263.3	54,865.5	54,986.4	55,213.6
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	9,245.8	45,144.4	45,144.4	45,449.8
ХҮҮ				
ТАТААС	117.5	594.4	594.4	526.9
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	44,900.0	9,126.7	9,247.6	9,236.9
ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	4,419.9	4,451.9	4,451.9	3,883.7
ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН				
ЦЭВЭР ЗЭЭЛ				1,587.1
УРСГАЛ ТЭНЦЭЛ	(4,419.9)	(4,451.9)	(4,451.9)	(5,470.8)
НИЙТ ТЭНЦЭЛ	-	-	-	-

Дээрх хүснэгтээс харахад сангийн яамнаас хянасан төсвөөс 2001,2 сая төгрөгөөр нэмэгдүүлж баталсан нь бодит байдалтай нийцээгүй байна.

Аймгийн СТСХ-ээс орлогын төлөвлөгөөг биелүүлэх зорилгоор төсвийн мөнгөөр иргэнээс худалдан авалт хийсэн судалгаа гаргаж үзэхэд татварт хамрагдахгүй хувь хүний данс руу шууд орж байсанд дүгнэлт хийж, “Е” баримт авахуулах, татварт хамруулах хяналтыг аймаг, сумдын төрийн сангаас эрс сайжруулан ажилласан

Төсвийн тухай хуульд заасан хугацаанд төсвийг үр ашигтай хэмнэлттэй байхаар баталж Сангийн яамны цахим программын нэгтгэлд оруулж байгаа ч ТТЗ-ын сумдын төсвийн төлөвлөлтийг бодиттой болгох, сумдын сум хөгжүүлэх сангийн эх үүсвэрийг Төсвийн тухай хуульд нийцүүлэн бодиттой төлөвлөх шаардлага байна.

1.3 Төсвийн тухай хуулийн 57 дугаар зүйлийн 57.2-д “Орон нутгийн төсвийг алдагдалгүй төлөвлөн баталж, хэрэгжүүлнэ” гэсэн заалтын дагуу 2016 оны урсгал зарлагын төслийг төсвийн бодлого, зорилтуудын хүрээнд бодит үйл ажиллагаанд зориулан хэмнэлттэй, үр ашигтай ажиллах зарчмыг баримтлан орлогын эх үүсвэрийн хэмжээнд багтаан Төсвийн тухай хууль, Засгийн газрын тогтоолууд болон бусад санхүүгийн заавар, журмуудыг үндэслэн хуваарилсан байна. Гэвч аймгийн

ТЕЗ-ын баталсан төсвийг хянахад ТЕЗ-ын СХС-гийн орлогод 11 сумдад бүгд 1587,1 сая төгрөгийн орлого төлөвлөсөн байна. Сум хөгжүүлэх сангийн зээл,зээлийн эргэн төлөлтөөр сумдуудын орлого, зарлагыг харилцан адилгүй төлөвлөж, зарим сумдуудад нэг ч төгрөгний орлого, зарлага төлөвлөгдөөгүй байна.	Сумдын СХСангийн тооцоо / сая.төг/					
	Сумдын нэр	төл	Эхний үл	Орлого	Зарлага	Эцсийн үлд
	Алтай	181.99	17.49	26.21	39.49	4.21
	Булган	8.10	8.10	79.99	87.95	0.14
	Буянт	80.00	37.75	47.18	79.97	4.96
	Дарви	-	5.63	41.27	35.62	11.29
	Дуут	190.10	0.01	13.34	12.00	1.35
	Зэрэг	-	10.91	27.65	20.76	17.80
	Манхан	167.86	30.61	102.15	21.75	111.01
	Дөргөн	-	12.83	20.55	12.19	21.19
	Мянгад	96.52	9.91	20.02	19.00	10.94
	Мөст	25.81	5.81	29.69	34.70	0.80
	Мөнхайрхан	142.77	3.69	138.06	136.50	5.25
	Ёенч	-	3.04	31.33	21.00	13.37
	Ховд	162.50	18.65	4.26	21.35	1.56
	Цэцэг	-	0.15	35.58	16.05	19.68
	Чандмань	25.00	9.16	123.32	117.83	14.64
	Эрдэнэбүрэн	-	7.93	28.70	21.95	14.68
	Жаргалант төв сул	506.52	8.46	261.22	244.95	24.74
	Нийт дүн	1,587.17	190.14	1,030.51	943.05	277.60

1.4 Монгол Улсын Засгийн газрын 2016 оны 153 тоот тогтоолын дагуу жижиг дунд үйлдвэрлэл хөгжсөн байдал, хүн амын тоо, газар нутгийн хэмжээ, өмнөх жилийн зээлийн ашиглалт, зээл авах хэрэгцээ шаардлага зэргийг харгалзан олгосон зээл, зориулалт бус, хугацаа хэтэрсэн зээлийн үлдэгдэл их байна.

Сангийн нэр	эхний үлдэгдэл / сая.төг/	эцсийн үлдэгдэл / сая.төг/	Авлага /сая.төг/	Өглөг /сая.төг/
17 сумын сум хөгжүүлэх сан	190.10	277.60	4,741.60	26.80

1.5 Төсвийн тухай хуулийн 4.1.27. “орон нутгийн төсөв” гэж аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас баталсан, тухайн шатны төсөвт харьяалагдах ерөнхийлөн захирагчийн бүрдүүлж, хуваарилан зарцуулах төсвийг заалтын дагуу аймгийн ИТХ-ын баталсан төсвийн орлого дээр сумын

ИТХ-ын баталсан төсвийн орлогыг нэмж программд оруулсан байна. Сумдын ИТХ-аар баталсан орлогыг аймгийн ТЭЗ-ын нэгтгэлтэй хянахад зарим сумдын орлого зөрүүтэй байна. Тухайлбал: Дуут сумын орон нутаг 5,5 сая төгрөгийн ангийн орлого нэмэлт дансаар зарцуулсан, Манхан сум ангийн 13,4 сая төгрөгний орлогыг аймгийн орлогын төлөвлөгөөнд тусгаагүй байна.

1.6 Сумдын татварын орлого тасарсантай холбоотойгоор 7419,5 сая төгрөгийг аймгийн төвлөрсөн төсвөөс сумдад санхүүгийн дэмжлэгээр олгожээ.

1.7 Аймгийн ИТХ-ын 2016 оны 10 сарын 21-ны өдрийн 03 тоот тогтоолоор орон нутгийн хөрөнгө оруулалтанд санхүүжилт батлаагүй бөгөөд замын сан, байгаль хамгаалах санд нийт дүнгээр 448,7 сая төгрөг баталсан бөгөөд хэрэгжүүлэх ажлын нэр төрөл, төсөвлөөгүй байна.

1.8 Аймгийн ОНХС-д 3664,2 сая төгрөг баталж гүйцэтгэлээр 3,664,1 сая төгрөг зарцуулжээ. Баталсан дүнгээс Чандмань суманд 3,6 сая төгрөг илүү олгож бусад сумдад 0,1-43,9 сая төгрөг дутуу олгож аймгийн ОНХС-д 145,9 сая төгрөгийг илүү зарцуулжээ.

Төсвийн байгууллагуудын түрээсийн орлогын бодиттой төлөвлөж орон нутгийн орлогыг бүрдүүлэх шаардлагатай байна.

1.9 Төрийн өмчийн болон орон нутгийн өмчийн байранд байрлаж түрээс төлж буй түрээслэгчдийн түрээсийн төлбөрийн хэмжээг Аймгийн ИТХ тэргүүлэгчдийн 2015 оны 166 дугаар тогтоолын “Түрээсийн төлбөрийн хэмжээг тогтоох тухай” тогтоолыг үндэслэн тогтоож эд хөрөнгийн түрээсийн орлогын 20% аймгийн Өмчийн санд, 80% -ийг тухайн байгууллагын дансанд төвлөрүүлж байна. Төрийн өмчийн түрээсийн байгууллагын судалгаанд 2016 оны байдлаар төсөвт 16 байгууллага, ОНӨААТҮ-ийн 2 газар хамрагдаж нийт 104,3 сая төгрөгийн орлого бүрдүүлэхээс 96,7 сая төгрөгийн орлого бүрдүүлэн ажилласан байна. Судалгаанаас харж дүгнэхэд зарим түрээслэгчдийн байр талбайн хэмжээ бодит хэмжээнээс бага, түрээслэж байгаа цайны газрын тоног төхөөрмжийн түрээсийг авдаггүй зөрчил байгаа тул үнэн бодит хэмжээг тогтоож орлогыг бүрэн төвлөрүүлэх зөвлөмж өглөө.

Боловсролын салбарын тусгай зориулалтын шилжүүлгийн төсвийг бодиттой төлөвлөх шаардлагатай байна.

1.10 Аймгийн дүнгээр ТШЗ-ын байгууллагуудад 272,8 сая төгрөгийн орлогын төлөвлөгөө баталснаас гүйцэтгэлээр 167,8 сая төгрөгийн орлого бүрдэж 105,0 сая төгрөгөөр орлого тасарсан нь сумдын соёлын төвүүдийн орлогын төлөвлөгөөг тасалсантай холбоотой байна.

1.11 Аймгийн хэмжээнд ТЗШ-ын байгууллагуудад 37711,8 сая төгрөгийн санхүүжилт олгосон бөгөөд санхүүгийн тайлангийн аудитаар боловсролын салбарын төсвийг харилцан адилгүй, хэлбэлзэл ихтэй төсөвлөсөн төдийгүй зарим байгууллагуудын төсвийн төлөвлөлтийг алдаа, зөрүүтэй хийсэн, байгууллага хооронд гүйлгэн зарцуулсан дутагдал байна. Мөн санхүүгийн тайлангийн аудитаар салбарын байгууллагуудын төсвийг албан ёсоор баталж тухайн төсвийн шууд захирагч нарт хүргүүлсэн тушаа байхгүй байна. Тухайлбал: Чандмань сумын сургуульд Булган сумын сургуулиас 10,0 сая төгрөг шилжүүлж олгосон,

- 1.12 Аймгийн Засаг даргын 2016 оны А/588 тоот захирамжаар боловсролын байгууллагуудын өрийг шийдвэрээр 33 байгууллагад 105,4 сая төгрөгийн нэг байгууллагаас нөгөөд шилжүүлэн зохицуулалт хийсэн, мөн 2016 оны А/292 тоот засаг даргын захирамжаар хүүхдийн цэцэрлэг, сургуулийн үдийн цайны хэмнэлтийн зардлаас цалин, НДШ, тээвэр шатахуун, урсгал засвар, томилолтонд 63,8 сая төгрөгийг гүйлгэн зарцуулах шийдвэр гарчээ.
- 1.13 Орон нутгийн болон тусгай зориулалтын шилжүүлгийн санхүүгийн дэмжлэгийн батлагдсан хэмжээнээс журнал ваучерээр 9 сумын төвлөрүүлэн захирагчид 139,9 сая төгрөгөөр илүү олгосон, 8 сумын төвлөрүүлэн захирагчдад 179,6 сая төгрөг дутуу олгосон нь батлагдсан төсвийг дураараа нэмж, хасч байгаа нь төсвийн төлөвлөлт бодитой бус байгааг харуулж байна.
- 1.14 Аймгийн дүнгээр хувийн хэвшлийн байгууллагуудад олгох санхүүжилтийг 476,7 сая төгрөгөөр баталж гүйцэтгэлээр 476,7 сая төгрөг олгосон байна.

БҮЛЭГ 2.ОРОН НУТГИЙН ОРЛОГЫН ГҮЙЦЭТГЭЛ

Орон нутгийн татварын орлого өмнөх оноос 165,0 сая төгрөгөөр нэмэгдсэн ч зарим нэр төрлийн татварын орлого тасарч баталсан дүнгээс 397,8 сая төгрөгөөр татварын орлого тасарсан байна.

2.1 Тайлант онд 60684,4 сая төгрөгний орлого бүрдүүлэх төлөвлөгөөтэйгээс, гүйцэтгэлээр 58861,9 сая төгрөгний орлого бүрдүүлж, батлагдсан орлогын төлөвлөгөөгөө 3 хувиар буюу 1822,5 сая төгрөгөөр дутуу бүрдүүлсэн байна.

Үүнээс : Татварын орлогын төлөвлөгөөгөө 95,2 хувь буюу 7842,8 , Татварын бус орлого 75,0 хувь буюу 781,5 , Хөрөнгийн орлого 96,1 хувь буюу 105,7, Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг буюу тусламжийн орлого 99,9 хувь буюу 49294,7 сая төгрөгөөр тус тус бүрдүүлсэн байна.

Аймгийн 2016 оны нийт орлогыг хүснэгтээр харуулбал: / сая төгрөгөөр /

ҮЗҮҮЛЭЛТ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
Нийт орлого ба тусламжийн дүн	60,684.4	58,861.9	1,822.5	97.0
Нийт орлого ба тусламжийн дүн	60,684.4	58,861.9	1,822.5	97.0
Суурь орлого	11,350.1	9,567.2	1,782.9	84.3
Урсгал орлого	11,158.1	9,461.5	1,696.6	84.8
Татварын орлого	8,240.7	7,842.8	397.8	95.2
Орлогын албан татвар	5,968.7	5,897.5	71.1	98.8
Хувь хүний орлогын албан татвар	6,787.6	6,716.5	71.1	99.0
Цалин хөлс, шагнал, урамшуулал болон тэдгээртэй адилтгах хөдөлмөр эрхлэлтийн орлого	6,088.9	6,237.7	(148.8)	102.4
Үйл ажиллагааны орлого	366.0	191.1	174.9	52.2
Шууд бус орлого	332.7	287.6	45.1	86.5
Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт	(818.9)	(818.9)	-	100.0
Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт	(818.9)	(818.9)	-	100.0
Хөрөнгийн албан татвар	884.0	818.1	65.9	92.5
Үл хөдлөх хөрөнгийн албан татвар	420.0	343.7	76.3	81.8
Бууны албан татвар	76.0	46.6	29.4	61.4
Авто тээвэр болон өөрөө явагч хэрэгсэлийн албан татвар	388.0	427.7	(39.7)	110.2
Бусад татвар төлбөр хураамж	1,388.0	1,127.2	260.8	81.2
Бусад нийтлэг төлбөр хураамж	826.8	463.9	362.9	56.1
Улсын тэмдэгийн хураамж	592.1	349.5	242.5	59.0
Түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны төлбөр	111.6	56.0	55.6	50.2
хог хаягдлын үйлчилгээний хураамж	123.1	58.3	64.8	47.4
Газрын төлбөр	216.3	139.5	76.8	64.5
Газрын төлбөр	191.3	135.4	55.8	70.8
Дуудлага худалдаа	25.0	4.1	20.9	16.3

Байгалийн нөөц ашигласны төлбөр	345.0	476.6	(131.6)	138.1
Ойн нөөц ашигласны төлбөр	12.1	17.0	(5.0)	141.2
Ан амьтаны нөөц ашигласны төлбөр	203.5	313.2	(109.6)	153.9
Ус рашааны нөөц ашигласны төлбөр	105.0	121.1	(16.1)	115.3
Байгалийн ургамлын нөөц ашигласны төлбөр	24.4	25.4	(1.0)	104.0
Бусад татвар	-	47.2	(47.2)	
Бусад татвар	-	47.2	(47.2)	
Татварын бус орлого	52,443.7	51,019.1	1,424.6	97.3
Нийтлэг татварын бус орлого	2,917.4	1,618.6	1,298.8	55.5
Хувьцааны ноогдол ашиг	15.0	11.5	3.5	76.7
Торгуулийн орлого	329.0	257.2	71.7	78.2
Төсөвт байгууллагын өөрийн орлого/ Орон нутгийн төсвийн байгууллагуудын /	60.6	86.8	(26.1)	143.1
Төсөвт байгууллагын өөрийн орлого/ Тусгай зориулалтын шилжүүлгийн байгууллагуудын	272.9	166.4	106.5	61.0
Бусад орлого	364.0	258.2	105.8	70.9
СХСангийн орлого эхний үлдэгдэл	1,875.9	838.5	1,037.4	44.7
Хөрөнгийн орлого	110.0	105.7	4.3	96.1
Төрийн болон орон нутгийн өмчид бүртгэлтэй хөрөнгө борлуулсаны орлого	110.0	105.7	4.3	96.1
Тусламжийн орлого	82.0	-	82.0	-
Хандив тусламж /дотоод/	50.0	-	50.0	-
Хандив тусламж /гадаад/	32.0	-	32.0	-
Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг	49,334.3	49,294.7	39.6	99.9
Тусгай зориулалтын шилжүүлгийн санхүүгийн дэмжлэг	37,711.9	37,712.0	(0.2)	100.0
Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас шилжүүлсэн орлого	3,664.2	3,664.1	0.1	100.0
Аймгийн төсөвт улсын төсвөөс олгох санхүүгийн дэмжлэг	7,958.3	7,918.6	39.7	99.5

2.2 Татварын орлого 397,8 сая төгрөгөөр тасарчээ.

Татварын орлогыг нэр төрлөөр нь авч үзвэл: Хувь хүний орлогын албан татвар 6787,6 сая төгрөгний төлөвлөгөөтэйгээс, гүйцэтгэлээр 6716,5 сая төгрөгний орлого бүрдүүлж 71,1 сая төгрөгөөр батлагдсан төлөвлөгөөгөө тасалсан байна. Энэ нь үйл ажиллагааны болон шууд бус орлогоо батлагдсан орлогын төлөвлөгөөнөөс 220,0 сая төгрөгөөр тасалж, цалин хөлс, шагнал, урамшуулал болон тэдгээртэй адилтгах хөдөлмөр эрхлэлтийн орлого 148,8 сая төгрөгөөр давуулан биелүүлснээс шалтгаалсан байна.

Хөрөнгийн албан татвар 884,0 сая төгрөгний орлогын төлөвлөгөөтэйгээс, гүйцэтгэлээр 818,1 сая төгрөгний орлого бүрдүүлж 65,9 сая төгрөгөөр орлогын төлөвлөгөөгөө тасалсан нь үл хөдлөх хөрөнгийн албан татвар, бууны албан татварыг 105,7 сая төгрөгөөр тасалж, АТӨЯХ-албан татвар 39,7 сая төгрөгөөр батлагдсан орлогын төлөвлөгөөгөө давуулан биелүүлсэнтэй холбоотой байна.

Бусад татвар төлбөр хураамжийн орлогын төлөвлөгөөгөө 260,8 сая төгрөгөөр тасалсан нь улсын тэмдэгтийн хураамж 242,5, түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны төлбөр 55,6, хог хаягдлын үйлчилгээний хураамж 64,8, газрын төлбөр 76,8 бүгд 439,7 сая төгрөгний татварын орлого тасалж, байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлого 131,6, бусад орлого 47,2 бүгд 178,8 сая төгрөгний орлого давуулан биелүүлсэн байна. Байгалийн нөөц ашигласны төлбөр 109,6 сая төгрөгөөр давуулан биелүүлсэний 83,2 хувь буюу 109,6 сая төгрөг ан амьтаны ашигласны төлбөр эзлэж байна.

2.3 **Татварын бус орлогын нэр төрлөөр авч үзвэл** : Татварын бус орлогын төлөвлөгөө батлагдсан хэмжээнээсээ 259,9 сая төгрөгөөр тасалсан нь хувьцааны ноогдол ашиг 3,5, торгуулийн орлого 71,7, төсөвт байгууллагын өөрийн орлого/ТЗШ/ 105,1, бусад орлого 105,8, төрийн болон орон нутгийн өмчид бүртгэлтэй хөрөнгө борлуулсаны орлого 4,3 бүгд 264,2 сая төгрөгөөр тасарч, тусламжийн орлого төлөвлөгдсөн хэмжээндээ ороогүй байна.

2.4 Тусгай зориулалтын шилжүүлэг, Орон нутгийн хөгжлийн сангийн нэгдсэн сангаас шилжүүлсэн орлого, Аймгийн төсөвт олгох санхүүгийн дэмжлэгээр 49334,3 сая төгрөг авахаас, гүйцэтгэлээр 49294,7 сая төгрөгний санхүүгийн дэмжлэг авсан байна.

2.5 Аймгийн төсөвт олгох санхүүгийн дэмжлэгийг 39,6 сая төгрөгөөр дутуу авсан, татварын орлого 397,8 сая төгрөгөөр тасарсан, татварын бус орлого 259,9 сая төгрөгөөр давж биелжээ. Аймгийн татварын орлого, Татварын бус, Санхүүгийн дэмжлэгийг хүснэгтээр харуулбал: /сая төгрөгөөр /

Сумдын нэрс	Татварын орлого			Татварын бус			Санхүүгийн дэмжлэг		
	Төл	Гүй	зөрүү	Төл	Гүй	зөрүү	Төл	Гүй	зөрүү
Алтай	57.0	41.1	15.9	10.9	6.0	4.9	1,738.7	1,732.2	6.5
Булган	116.7	85.1	31.5	22.6	8.0	14.6	3,685.8	3,674.2	11.6
Буянт	66.8	52.8	14.0	8.0	0.8	7.2	1,484.1	1,488.3	(4.2)
Дарви	37.3	30.3	7.0	8.0	6.7	1.3	1,734.9	1,748.4	(13.5)
Дуут	51.7	39.5	12.2	7.7	1.6	6.1	1,247.9	1,253.6	(5.7)
Зэрэг	33.9	35.7	(1.8)	8.0	3.7	4.3	1,922.0	1,915.8	6.2
Манхан	41.1	41.9	(0.9)	8.0	3.1	4.9	1,998.8	1,992.7	6.1
Дөргөн	36.2	38.2	(2.0)	7.9	3.5	4.4	1,725.1	1,727.7	(2.6)
Мянгад	51.3	40.7	10.6	8.0	3.1	4.9	1,559.9	1,561.9	(2.0)
Мөст	94.3	98.9	(4.5)	8.8	3.4	5.4	1,566.6	1,571.0	(4.4)
Мөнххайрхан	31.3	23.6	7.7	8.0	2.1	5.9	1,443.5	1,442.1	1.4
Үенч	74.4	93.4	(19.0)	9.2	3.3	5.9	2,071.3	2,027.3	44.0
Ховд	30.8	19.3	11.5	8.1	1.0	7.1	1,682.0	1,680.9	1.1
Цэцэг	77.5	117.9	(40.4)	8.2	2.5	5.7	1,623.0	1,618.8	4.2
Чандмань	39.2	38.2	0.9	8.0	3.6	4.4	1,683.6	1,688.7	(5.2)
Эрдэнэбүрэн	34.4	30.5	3.9	8.0	2.5	5.5	1,427.5	1,447.1	(19.6)
Жаргалант	450.2	346.3	104.0	94.0	84.9	9.1	13,522.5	13,424.0	98.5
Төвлөрсөн	6,916.7	6,669.6	247.1	800.0	641.7	158.3	7,217.0	7,299.7	(82.7)
Нийт дүн	8,240.7	7,842.8	397.8	1,041.5	781.5	259.9	49,334.3	49,294.7	39.6

Татварын орлогыг Зэрэг 1,8, Манхан 0,9, Дөргөн 2,0, Мөст 4,5, Үенч 19,0, Цэцэг 40,4 сая төгрөгөөр татварын орлогоо давуулан биелүүлж, бусад сумдууд 0,9-104,0 сая төгрөгөөр татварын орлого тасалсан байна.

2.6 Орлогын гүйцэтгэлийг өмнөх онтой харьцуулбал: Татварын орлого 165,2, Тусгай зориулалтын шилжүүлгийн орлого 3479,2, татварын бус орлого 704,3, сая төгрөгөөр нэмэгдэж, Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас шилжүүлсэн орлого 674,3, улсын төсөвт олгох санхүүгийн дэмжлэг 976,2 сая төгрөгөөр тус тус буурсан байна.

Үзүүлэлт	2015	2016	зөрүү
	гүй	гүй	
Татварын орлого	7,677.6	7,842.8	(165.2)
Татварын бус орлого	1,020.1	1,724.4	(704.3)
Тусгай зориулалтын шилжүүлгийн орлого	34,232.8	37,712.0	(3,479.2)
Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас шилжүүлсэн орлого	4,338.4	3,664.1	674.3
Улсын төсөвт олгох санхүүгийн дэмжлэг	8,894.8	7,918.6	976.2
Нийт дүн	56,163.7	58,861.9	(2,698.2)

Нийт орлогын бүтцийг авч үзвэл: Татварын орлого 13,3%, Татварын бус орлого 2,9 %, Тусгай зориулалтын шилжүүлгийн орлого 64,1%, ОНХС-ийн нэгдсэн сангаас шилжүүлсэн орлого 6,2 %, Улсын төсвөөс орон нутгийн төсөвт олгох санхүүгийн дэмжлэг 13,5 % хувийг эзлэж байна.



2.7 Санхүүгийн тайлангийн аудитаар орлого данстай холбоотой дараахь зөрчил илэрлээ. Үүнд :

- Аймгийн нийт орлого 783,7 сая төгрөгөөр тасарсанаас татварын орлого 397,8 сая төгрөгөөр тасарсан,
- Татварын орлогыг Зэрэг 1,8, Манхан 0,9, Дөргөн 2,0, Мөст 4,5, Үенч 19,0, Цэцэг 40,4 сая төгрөгөөр татварын орлогоо давуулан биелүүлж, бусад сумдууд 0,9-104,0 сая төгрөгөөр татварын орлого тасалсан,
- Манхан сум ангийн 13,4 сая төгрөгний орлогыг аймгийн орлогын төлөвлөгөөнд тусгаагүй,
- Дуут сум ангийн орлогын 5,5 сая төгрөгийн татварын орлогын мэдээ, тайланд тусгаагүй,
- Эмийн эргэлтийн сангууд НӨАТ-ын борлуулалтын орлогыг зөв тайлагнаагүй, бэлнээр хураасан орлогыг харилцах дансанд бүрэн төвлөрүүлээгүй,
- Орлого бүрэн тусгаагүй 42 байгууллагын 323,0 сая төгрөгний орлого дутуу тайлагнасныг залруулга хийгдсэн,
- Төсөвт байгууллагын өөрийн орлого /ТЗШ/-ийн 272,9 сая төгрөгний өөрийн орлого батлагдсанаас, гүйцэтгэлээр 167,8 сая төгрөгний орлого бүрдүүлж 105,1 сая төгрөгөөр тасалсан байна. Биеийн тамир спортын газар- 24,4 сая , Хөгжим драмын театр 36,9 сая үлдэх бүх байгууллагууд өөрийн орлогын төлөвлөгөөгөө 1,0-3,5 сая төгрөгөөр тус тус тасалсан,
- Орон нутгийн төсөвт байгууллагуудын өөрийн орлогын төлөвлөгөө 60,6 сая , гүйцэтгэлээр 86,6 сая төгрөг бүрдүүлж 26,1 сая төгрөгөөр биелүүлсэн боловч аймгийн Засаг даргын Тамгын газар 10,9, Жаргалант сум 2,6, Мянгад сум 0,1, Үенч сум 0,1 сая төгрөгөөр тус тус орлогын төлөвлөгөөгөө давуулан биелүүлж, Буянт, Дарви, Дөргөн, Мөст, Ховд, Цэцэг сумдууд нэг ч төгрөгний өөрийн орлого бүрдүүлээгүй, бусад сумдууд орлогын төлөвлөгөөгөө тасалсан зэрэг алдаа зөрчлүүд байна.

БҮЛЭГ 3.ОРОН НУТГИЙН ЗАРЛАГЫН ГҮЙЦЭТГЭЛ

Зардлыг зүйл анги бүрээр баталсан дүнтэй харьцуулахад цалин хөлс, тогтмол зардлуудыг 368,9 сая төгрөгөөр хэмнэж бусад бараа үйлчилгээний зардалд гүйлгэн зарцуулжээ.

3.1 2016 онд 60684,4 сая төгрөгний зардлын төлөвлөгөөтэйгээс, гүйцэтгэлээр 59216,0 сая төгрөгний зардал гаргаж батлагдсан зардлын төлөвлөгөөг 1468,4 сая төгрөгөөр хэмнэсэн байна.

3.2 Цалин хөлс болон нэмэгдэл урамшуулал 29529,9 сая төгрөгний төлөвлөгөөтэйгээс, гүйцэтгэлээр

29405,0 сая төгрөгний зардал гарч батлагдсан төсөвт зардлаа 124,9 сая төгрөгөөр хэмнэсэн нь үндсэн цалин 773,1 сая төгрөгөөр хэтрүүлж, нэмэгдэл 535,1, унаа, хоолны хөнгөлөлт 4,4, урамшуулал 140,9, гэрээт ажлын хөлс 217,6 бүгд 898,0 сая төгрөгөөр хэмнэсэнтэй холбоотой байна. Ажил олгогчоос



- нийгмийн даатгалд төлөх шимтгэл батлагдсан төсөвт зардлаасаа 30,8 сая төгрөгөөр хэмнэсэн байна.
- 3.3 Байр ашиглалтай холбоотой тогтмол зардал 4565,0 сая төгрөгний төлөвлөгөөтэйгээс, гүйцэтгэлээр 4321,0 сая төгрөгний зардал гарч 244,0 сая төгрөгөөр хэмнэсэн байна. Үүнд : гэрэл цахилгаан 159,2, түлш халаалт 52,6, цэвэр бохир ус 31,3, байрны түрээс 1,0 сая төгрөгөөр тус тус хэмнэсэн байна
- 3.4 Хангамж, бараа материалын зардалд 1060,4 сая төгрөг төлөвлөгдсөнөөс, гүйцэтгэлээр 1250,2 сая төгрөгний зардал гаргаж 189,8 сая төгрөгөөр хэтрүүлэн зарцуулсан байна. Үүнд: бичиг хэрэг 64,7, тээвэр шатахуун 88,3, шуудан холбоо, интернэтийн төлбөр 18,7, Бага үнэтэй түргэн элэгдэх ахуйн эд зүйлс 116,5 сая төгрөгөөр тус тус хэтрүүлэн зарцуулжээ.
- 3.5 Норматив зардал 3010,6 сая төгрөг батлагдсанаас, гүйцэтгэлээр 2994,7 сая төгрөгний зардал гарч, төсвөө 15,9 сая төгрөгөөр хэмнэсэн байна. Үүнд : эм бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл 56,3, нормын хувцас, зөөлөн эдлэл 37,0 сая төгрөгөөр тус тус хэтрүүлэн зарцуулж, хоол хүнсний зардал 109,1 сая төгрөгөөр хэмнэсэн байна.
- 3.6 Эд хогшил урсгал засварын зардал батлагдсан хэмжээнээсээ 77,2 сая төгрөгөөр хэтрүүлсэн нь багаж техник хэрэгсэл 15,9, тавилга 9,2, урсгал засвар 52,1 сая төгрөгөөр тус тус хэтрүүлсэнтэй холбоотой байна.
- 3.7 Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр хураамжийн зардалд 1200,4 сая төгрөг батлагдсанаас, гүйцэтгэлээр 1163,5 сая төгрөг зарцуулж төсвөөс 36,9 сая төгрөгөөр хэмнэсэн байна. Үүнээс мэдээлэл, технологийн үйлчилгээ 60,6 сая , аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох зардал 3,0 сая төгрөгөөр тус тус хэтрүүлж бусад даатгалын үйлчилгээ, тээврийн хэрэгсэлийн татвар, тээврийн хэрэгсэлийн оношлогоо, газрын төлбөрийн зардлууд хэмнэгдсэн байна
- 3.8 Бараа үйлчилгээний бусад зардалд 2458,5 сая төгрөг батлагдсанаас, гүйцэтгэлээр 1750,5 сая төгрөгийн зардал гаргаж батлагдсан төсвөө 708,0 сая төгрөгөөр хэтрүүлэн зарцуулсан байна. Бараа үйлчилгээний бусад зардалд сумдын хувьд сумын засаг даргын нөөц хөрөнгө, аймгийн төвийн төсвийн байгууллагуудын хувьд аймгийн хөрөнгө оруулалтаас Шүүхийн шийдвэрээр олгосон 168,0, ЗДТГ-229,3, Засаг дарга дансны 393,6, /Замын сан-231,3, Байгаль хамгаалах сан -83,0, бусад 79,3/ биеийн тамир спортын хороо 37,3, газрын алба 36,1 сая төгрөгний ихээхэн өндөр дүнтэй зардлууд тайлагнасан байна.
- 3.9 Жаргалант сумын гэр хороолол буюу зөөврөөр ус ашигладаг айл өрхийн усны үнийн зөрүүд орон нутгийн төсвөөс 2016 онд 50,3 сая төгрөг олгожээ.
- 3.10 Хувийн хэвшлийн байгууллагад олгох татаас 476,7 сая төгрөгөөр батлагдаж гүйцэтгэлээр 793,1 сая төгрөгний гүйцэтгэл гарсан батлагдсан төсвөө 316,4 сая төгрөгөөр хэтрүүлсэн байна. Энэ нь авто тээврийн хэрэгсэлийн хариуцлагын даатгалд 37,2, Ахмад, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн унааны хөнгөлөлт 35,0, Хот тохижилтын зардалд 316,4, хувийн цэцэрлэгт 404,0 сая төгрөгний зардал олгожээ.
- 3.11 Урсгал шилжүүлгийн зардалд 9225,0 сая төгрөг төлөвлөгдсөнөөс, гүйцэтгэлээр 9344,3 сая төгрөгний зардал гаргаж 374,9 сая төгрөгөөр хэмнэсэн байна. Үүнд: Нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж 353,2, төрөөс иргэдэд

олгох тэтгэмж урамшуулал 47,6 сая төгрөгөөр хэмнэж, Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн тэтгэмж 5,2, Хөдөө орон нутагт тогтвортой суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг 14,8, нэг удаагийн тэтгэмж урамшуулал 6,0 сая төгрөгөөр тус тус хэмнэсэн байна.

3.12 Хөрөнгийн зардалд 3883,7 сая төгрөгний төсөв батлагдаж, гүйцэтгэлээр 3734,8 сая төгрөг зарцуулж 148,9 сая төгрөгөөр төсвөө хэмнэсэн байна. Үүнд : барилга байгууламж 772,8, тоног төхөөрөмж 220,9 сая төгрөгөөр хэмнэж, Их засвар 309,0, бусад хөрөнгө 535,9 сая төгрөгөөр хэтрүүлсэн байна.

Төсвийн гүйцэтгэлийн зарлагын тайланг хүснэгтээр харуулбал : /сая төг/

/ сая төгрөгөөр
/

Үзүүлэлт	Тайлант оны	
	Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	60,684.4	59,216.0
УРСГАЛ ЗАРДАЛ	55,213.6	54,759.8
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	45,461.6	44,572.1
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	29,529.9	29,405.0
Үндсэн цалин	23,577.2	24,350.2
Нэмэгдэл	2,777.9	2,242.8
Унаа хоолны хөнгөлөлт	59.4	55.0
Урамшуулал	1,625.9	1,485.0
Гэрээт ажлын хөлс	1,489.5	1,271.9
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	3,252.5	3,221.7
Тэтгэврийн даатгал	2,067.5	2,087.2
Тэтгэмжийн даатгал	236.3	222.9
ҮОМШӨ-ний даатгал	298.6	277.7
Ажилгүйдлийн даатгал	59.1	67.1
Эрүүл мэндийн даатгал	590.9	566.8
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	4,565.0	4,321.0
Гэрэл, цахилгаан	621.7	462.5
Түлш, халаалт	3,459.5	3,406.9
Цэвэр, бохир ус	479.2	447.9
Байрны түрээс	4.6	3.6
Хангамж, бараа материалын зардал	1,060.4	1,250.2
Бичиг хэрэг	96.3	161.0
Тээвэр, шатахуун	612.6	700.9
Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	133.2	152.0
Ном, хэвлэл	35.1	23.4
Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	129.5	42.8
Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	53.7	170.2

Нормативт зардал	3,010.6	2,994.7
Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	206.8	263.1
Хоол, хүнс	2,681.4	2,572.3
Нормын хувцас, зөөлөн эдлэл	122.3	159.3
Эд хогшил, урсгал засварын зардал	188.5	265.7
Багаж, техник, хэрэгсэл	37.9	53.9
Тавилга	7.2	16.3
Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	-	-
Урсгал засвар	143.4	195.5
Томилолт, зочны зардал	195.7	199.9
Гадаад албан томилолт	-	0.4
Дотоод албан томилолт	195.7	199.5
Зочин төлөөлөгч хүлээн авах	-	-
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,200.4	1,163.5
Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,131.7	1,041.1
Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	25.2	28.1
Даатгалын үйлчилгээ	6.0	5.5
Тээврийн хэрэгслийн татвар	7.9	7.5
Тээврийн хэрэгслийн оношлогоо	1.0	0.6
Мэдээлэл, технологийн үйлчилгээ	10.8	71.4
Газрын төлбөр	3.9	2.6
Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	14.1	6.7
Бараа үйлчилгээний бусад зардал	2,458.5	1,750.5
Бараа үйлчилгээний бусад зардал	2,204.4	1,529.3
Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	254.1	221.1
ТАТААС	527.0	843.4
Төрийн өмчит байгууллагад олгох татаас	50.3	50.3
Төрийн өмчит байгууллагад олгох татаас	50.3	50.3
Хувийн хэвшлийн байгууллагад олгох татаас	476.7	793.1
Хувийн хэвшлийн байгууллагад олгох татаас	476.7	793.1
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	9,225.0	9,344.3
Засгийн газрын урсгал шилжүүлэг	-	494.2
Засгийн газрын дотоод шилжүүлэг	-	494.2
Бусад урсгал шилжүүлэг	9,225.0	8,850.1
Нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмж	-	-
Нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж	7,209.5	6,856.2
Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	45.2	45.1
Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	879.6	832.0
Ээлжийн амралтаар нутаг явах унааны хөнгөлөлт	-	0.1

Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	523.1	528.3
Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	536.4	551.2
Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	31.2	37.1
ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	3,883.7	3,734.8
Дотоод эх үүсвэрээр	3,883.7	3,734.8
Барилга байгууламж	1,906.5	1,133.7
Их засвар	509.0	818.0
Тоног төхөөрөмж	448.6	227.6
Бусад хөрөнгө	1,019.6	1,555.5
ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	1,587.2	721.4
Эргэж төлөгдөх зээл	1,587.2	721.4
ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	60,684.4	59,231.2
УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	38,083.9	41,812.4
Засгийн газрын тусгай сангаас санхүүжих	372.0	436.5
Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	37,711.9	37,711.9
Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас санхүүжих	-	3,664.1
ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	20,390.0	16,242.8
Орон нутгийн төсвөөс	16,726.0	16,242.8
Орон нутгийн хөгжлийн сангаас санхүүжих	3,664.1	-
ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	2,210.5	1,176.1
Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	268.4	211.4
Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	1,523.2	899.4
Урьд оны үлдэгдлээс санхүүжих	419.0	52.1
Гадаадын эх үүсвэрээс санхүүжих	-	13.2
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	549.6
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	564.8

Засгийн газрын төсвийн хэмнэлтийн горимтд шилжүүлэх тухай 147 дугаар тогтоолыг зарим байгууллагууд хэрэгжүүлээгүй байна.

3.13 Томилолтын зардал 3,8 сая төгрөгөөр хэтэрсэн боловч гадаад томилолтонд нэг ч төгрөг төсөвлөгдөөгүй байхад 0,4 сая төгрөгийн зардал гаргасан байна. Гэтэл аудитын хугацаанд хийгдсэн судалгаагаар томилолтын зардалд 70,7 сая төгрөгийн зардал гаргасан байна. Үүнд: Аймгийн ЗДТГ, аймгийн ИТХ, БОАЖ Газрууд гадаад томилолтоор ажилласан ч гадаад томилолтын зардалд тайлагнаагүй байна.

3.14 Төсвийн захирагчийн буруутай үйл ажиллагаанаас ажлаас халагдсан хүмүүсийн цалин буцаан олгож төсвийн зардал гаргасан алдааг тайлант онд мөн давтан гарсаар байна. Тухайлбал: Аймгийн ИТХ 8,0 сая, Жаргалант сумын 1 дүгээр сургууль 4,6 сая, 7 дугаар сургууль 4,3 сая, 3 дугаар сургууль 7,3 сая төгрөгийг тус тус шүүхийн шийдвэрээр олгожээ.

3.15 Орон нутгийн төсөвт байгууллагууд шатахууны зардалд 613,3 сая төгрөг батлагдсанаас 704,3 сая төгрөг зарцуулж батлагдсан төсвөө 91,1 сая төгрөгөөр хэтрүүлж зарцуулсан байна.

3.16 Урсгал зардалд 169,3 сая төгрөг батлагдаж 227,8 сая төгрөг зарцуулж батлагдсан зардлаа 58,5 сая төгрөгөөр, Тавилга эд хогшил худалдан авах зардлаа ихэнх төсөвт байгууллагууд БҮТЭЗүйл зардалд батлагдсан төсвөөс бэлтгэсэн байна. Үүнд 44,2 сая төгрөг зарцуулахаас 76,1 сая төгрөгийн хөрөнгө худалдан авч зохих зардалд бүртгэсэн байна.

3.17 “Засаг дарга” данснаас төлөвлөгдөөгүй, Засаг даргын шийдвэрээр 79,5 сая төгрөг, Орон нутгийн хөрөнгө оруулалт данснаас төлөвлөгдөөгүй 257,0 сая төгрөгний зардал гарсан байна. Үүнд Урьд оны санхүүгийн дэмжлэгийн дутуу 58,6, Кеналхап ХХК-д зам тавьсан ажлын үлдэгдэл санхүүжилт /шүүхийн шийдвэрээр 168,0, ББМЗТ-Мөнххайрхан сумын Нутгийн удирдлагын ордонь санхүүжилтэнд 30,4 сая төгрөг тус тус олгогдсон байна

Нэмэлт санхүүжилтийн дансаар 1424,4 сая төгрөгийн орлого бүрдэж 1361,0 сая төгрөгийн зардал гаргаж 63,4 сая төгрөгийн төрийн санд төвлөрүүлжээ.

3.18 Жаргалант сумын төрийн санд нэмэлт дансаар 31,9 сая, аймгийн төрийн санд 19,1 сая төгрөг тус тус төвлөрсөн байна.

3.19 Төсвийн төвлөрүүлэн захирагчийн харьяа байгууллагуудад хийсэн төрийн албан хаагчдын судалгаанаас үзэхэд Аймгийн ЗДТГ-т 55 дээш насны эмэгтэй 2, Булган сумын ЗДТГ-т 60 дээш насны эрэгтэй 1 ажиллаж байна. Тэтгэвэрт гараад ажиллаж байгаа төрийн албан хаагч байхгүй байна.

3.20 Тайлант онд төсвийн 152 байгууллагуудад 3832 хүн ажиллаж баталсан дүнгээс 7 орон тоо хэмнэж ажилласан байна.

Үзүүлэлт	Өмнөх оны	Тодотгосон	Гүйцэтгэл	Зөрүү
БАЙГУУЛЛАГЫН ТОО	150.0	152.0	152.0	-
Төсвийн байгууллага	130.0	132.0	132.0	-
Төсвөөс гадуур байгууллага	20.0	20.0	20.0	-
АЖИЛЛАГСДЫН ТОО	3,759.0	3,839.0	3,832.0	(7.0)
Удирдах ажилтан	264.0	261.0	256.0	(5.0)
Гүйцэтгэх ажилтан	2,053.0	2,180.0	2,291.0	111.0
Үйлчлэх ажилтан	1,012.0	931.0	866.0	(65.0)
Гэрээт ажилтан	430.0	467.0	419.0	(48.0)

Санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд өгөгдсөн зөвлөмжийн дагуу 4600,6 сая төгрөгийн залруулга хийж аймгийн ТЕЗ-ын тайланг нэгтгүүлсэн боловч цаашид дотоод хяналтын байгууллагуудын ажлыг эрчимжүүлж, бүх шатны хяналтыг сайжруулах шаардлагатай байна.

- 3.21 ОН-ийн ТЭЗ-ийн санхүүгийн нэгтгэсэн тайланд нэгтгэдэг орон нутгаас санхүүждэг аудитад хамрагдвал зохих 224 байгууллагаас 223 байгууллага аудитад хамрагдан 94 байгууллагыг түүвэрлэн хянаж, 3 байгууллагад итгэл үзүүлж, 127 байгууллагад дүгнэлт гаргасан байна. Эе эвийн хүч ОНӨААТҮГ-ын удирдлага солигдсон, үйл ажиллагаа явуулаагүйгээс аудитад хамрагдаагүй байна.
- 3.22 Орон нутгийн 17 төсвийн төвлөрүүлэн захирагч, 28 орон нутгийн өмчийн болон өмчийн оролцоотой ААН, 85 төсвийн шууд захирагчийн 2016 оны санхүүгийн тайланд аудит хийж 13 тэрбум 420,6 сая төгрөгийн алдаа, зөрчил илрүүлснээс 7 тэрбум 645,4 сая төгрөгийн материаллаг алдааг залруулж, 4 тэрбум 600,6 сая төгрөгийн зөрчил, дутагдлыг арилгуулах зөвлөмж өгч, 139,4 сая төгрөгийн 44 акт, 1 тэрбум 35,8 сая төгрөгийн 33 албан шаардлага бичлээ.
- 3.23 Аудитаар ОН-ийн төсвийн ерөнхийлөн захирагчдын санхүүгийн нэгтгэсэн 86 тайланд зөрчилгүй, 40 тайланд хязгаарлалттай санал дүгнэлт өгсөн байна. Хязгаарлалттай дүгнэлт авсан 40 байгууллагын 13 байгууллага нь орон нутгийн өмчит болон өмчийн оролцоотой ААН-ын тайлангууд байгаагаас үзэхэд төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой ААН-үүдийн нягтлан бодох бүртгэлийн болон тайлагналын стандарт шаардлагад нийцэж тайлагнаагүй гэсэн дүгнэлт өгч байна.
- 3.24 Төсвийн тухай хуульд заасны дагуу төсвийн ерөнхийлөн захирагчдын бүтцэд дотоод аудитыг хэрэгжүүлэх чиг үүрэг бүхий нэгж байгуулагдан ажиллаж байна. Тус алба нь 2016 онд үйл ажиллагааны төлөвлөгөө, хяналт шалгалтын графикаар 8 сумын 56 төсөвт байгууллага болон аймгийн төвийн 45 төсөвт байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит үйлдвэрийн газар бүгд 101 байгууллагад хяналт шалгалт хийхээр төлөвлөж, гүйцэтгэлээр аймгийн төвийн 39 байгууллагад төлөвлөгөөт шалгалт хийж 206,0 сая төгрөгний төлбөр зөрчил илрүүлсэн байгаа нь нийт хяналт хэрэгжүүлбэл зохих байгууллагынхаа 38,6 хувийг хамруулсан тоон мэдээтэй байна.
- 3.25 Төрийн сангийн дотоод хяналтыг хэрэгжүүлдэг 1 ажилтан ажилладаг бөгөөд 2016 онд ганцхан Чандмань сумын төрийн сангийн үйл ажиллагаанд мөрдөх хууль эрх зүйн актын хэрэгжилтийг шалгаж эдийн засгийн ангилал зөрчсөн гүйлгээг байгууллага бүрээр гарган дүгнэлт, зөвлөмж хүргүүлэн ажилласан тайлангаас өөр ажил хийгдээгүй байна.
- 3.26 Аймгийн хэмжээнд санхүү, төсвийн сахилга, хариуцлагыг сайжруулж, өр авлага барагдуулах талаар гарсан аймгийн Засаг даргын 2016 оны 07 дугаар “Албан даалгавар”, зарлага, санхүүжилтыг хугацаанд нь гаргах, хэмнэлтийн горимыг хэрэгжүүлж, оны эцэст аймаг, сумын хэмжээнд өргүй гарах арга хэмжээ авч сум, байгууллагуудад байнга үүрэг чиглэл өгч ажилласан байна.
- 3.27 Аймгийн Аудитын газрын 2015 оны зөвлөмжийг хэрэгжүүлэх, төсвийн авлагыг барагдуулах зорилгоор орон нутгийн төсвийн авлагын байдалд дүгнэлт хийж төсвийн хөрөнгө оруулалтын эргэж төлөгдөх нөхцөлөөр авсан хөрөнгийн авлагыг барагдуулахаар 4 компанид албан бичиг хүргүүлж, хугацаандаа хариу өгөхгүй байгаа компанидын авлагын жагсаалтыг аймгийн ЗДТГ-ын хууль зүйн хэлтэст хүргүүлж 200,0 гаруй сая төгрөгийг барагдуулсан байна.

БҮЛЭГ 4. ОРОН НУТГИЙН ТӨСВИЙН ҮР ДҮНГИЙН ҮЗҮҮЛЭЛТ

Өмнөх оны гүйцэтгэлээс тайлант оны зардал 2538.8 сая төгрөгөөр өсөж, баталсан дүнгээс нийт зарлагыг 1468,4 сая төгрөгөөр дутуу санхүүжүүлж (-440,8) сая төгрөгийн үр дүнтэй ажиллажээ.

Төсвийн тухай хуулийн 57 дугаар зүйлийн 57.2-д “орон нутгийн төсвийг алдагдалгүй төлөвлөн баталж, хэрэгжүүлнэ” гэсэн заалтын дагуу 2016 оны эх үүсвэр, зарлагыг тэнцүү баталсан байна. Нийт 58861,9 сая төгрөгийн орлогыг санхүүжүүлсэний 14,3 хувь буюу 8456,4 сая төгрөгийн урсгал орлогоор, 0,1 хувь буюу 105,4 сая төгрөг нь хөрөнгийн орлогоор, 85,6 хувь буюу 50299,6 сая тусламжийн орлогоор санхүүжүүлж байна.

Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Анх батлагдсан	2016 он		
			Тодотгосон төсөв	Гүйцэтгэл	Зөрүү
А	1.00	2	3.00	4.00	5=4-3
НИЙТ ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН	56,199.17	59,317.60	60,684.42	58,861.90	(1,822.52)
А. УРСГАЛ ОРЛОГЫН ДҮН	8,500.00	9733.8	9,298.05	8,456.54	(841.51)
1. Татварын орлого	7,677.60	8,825	8,240.69	7,842.85	(397.84)
2. Татварын бус орлого	822.40	909	1,057.36	613.69	(443.67)
Б. ХӨРӨНГИЙН ОРЛОГО	112.37	100	110.00	105.74	(4.26)
В. ТУСЛАМЖИЙН ОРЛОГО	47,586.80	49,484	51,276.37	50,299.62	(976.75)
НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	56,677.20	59,317.60	60,684.42	59,216.00	(1,468.42)
А. УРСГАЛ ЗАРЛАГА	51,074.91	54,866	55,213.57	54,759.77	(453.79)
1. Бараа, үйлчилгээний зардал	41,671.61	45,024	45,461.57	44,572.09	(889.48)
1.1. Цалин, хөлс	28,683.32	29,577	29,529.92	29,405.01	(124.91)
1.2. Нийгмийн даатгалын шимтгэл	3,139.78	3,257	3,252.46	3,221.68	(30.77)
1.3. Бараа, үйлчилгээний бусад зардал	9,848.51	12,189	12,679.19	11,945.40	(733.79)
2. Зээлийн үйлчилгээний төлбөр					-
3. Татаас ба урсгал шилжүүлэг	9,403.30	9,842	9,751.99	10,187.68	435.69
3.1. Татаас	401.47	594	526.99	843.37	316.38
3.2. Урсгал шилжүүлэг	9,001.84	9,247	9,225.00	9,344.31	119.30
Б. ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	5,602.28	4,452	3,883.69	3,734.82	(148.87)
В. ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ЦЭВЭР ЗЭЭЛ	-	-	1,587.17	721.41	(865.76)
1. Эргэж төлөгдөх дотоод цэвэр зээл			1,587.17	721.41	(865.76)
2. Эргэж төлөгдөх гадаад цэвэр зээл					-
УРСГАЛ ТЭНЦЭЛ	(42,574.91)	(45,132)	(45,915.51)	(46,303.23)	(387.72)
НИЙТ ТЭНЦЭЛ	(478.03)	-	-	(354.10)	(354.10)
АЛДАГДЛЫГ САНХҮҮЖҮҮЛСЭН ЭХ ҮҮСВЭР					-
1. Мөнгөн хөрөнгийн цэвэр өөрчлөлт	-			139.13	139.13
2. Өмнөх оны үлдэгдлээс санхүүжих	(478.03)	0.0	-	301.72	301.72
3. Бусад					-

2016 оны төсвийн зарлагын гүйцэтгэлийн хувьд нийт тэнцэл 440,8 сая төгрөгөөр орлогоосоо, зарлага нь их байгаа нь өмнөх оны мөнгөн хөрөнгийн үлдэгдэлээс санхүүжүүлсэн байна.

ЕРӨНХИЙ ДҮГНЭЛТ:

- Төсвийн тухай хуулийн дагуу аймгийн ТЕЗ-ын төсвийн орлого, зарлагыг төсвийн бодлого, зорилтуудын хүрээнд төлөвлөсөн ч сангийн яамнаас хянасан төсвөөс 2001,2 сая төгрөгөөр нэмэгдүүлж баталсан төдийгүй зарим сан, боловсролын байгууллагуудын төсвийг бодиттой төлөвлөх шаардлагатай байна.

- ## АУДИТЫН ЗӨВЛӨМЖ

Аймгийн Боловсрол Соёл урлагын газрын дарга Пүрэвхүү-д

- Орон нутгийн өмчийн албаны дарга Б.Гомбосүрэнд:**

- ### ТАЙЛАНТАЙ ТАНИЛЦСАН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Л.ГАЛБАДРАХ

ХҮҮНАСАН:

АУДИТЫН МЕНЕЖЕР

А.ЦЭЦЭГСҮРЭН

БИЧСЭН:

АХЛАХ АУДИТОР
АУДИТОР

Д.ХИШГЭЭ
Д.НАРАНТУУЛ